



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.12 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/570 тоот дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/1021 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу илэрхийлж “Зөрчилгүй” дүгнэлт авч, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж ажилласан тул 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Ж.Даш/ нарт үүрэг болгосугай.

3. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Даваадорж/, гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/-нарт даалгасугай.

ДАРГА



П.ДАВААДОРЖ



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.4 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/1021 дүгээр удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компани 2021 оны санхүүгийн тайлангийн дүнгээр 184.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй гэж үзсүгэй.

2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГА  П.ДАВААДОРЖ



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Компанийн гүйцэтгэх захиралтай 2021 онд байгуулсан контрактын биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох журам”, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн а/839 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийг 91.3 оноогоор дүгнэж “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлт, дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Даваадорж/, гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/ нарт даалгасугай.

ДАРГА  П.ДАВААДОРЖ





Дулаан Шарын гол ТӨХЖ-ийн Төлөөлөн
 удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар
 сарын 23-ны өдрийн хурлын 09 дүгээр
 тогтоолын хавсралт

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН КОНТРАКТЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Дүгнэх үзүүлэлт	хэмжих нэгж	2021 он				Дулаан дамжуулах, түгээх сүлжээ			
			2020 оны гүйц	төлөв	гүйц	зөрүү	хувь	Авбал зохих оноо	Авсан оноо	
1	Эдийн засгийн үзүүлэлт									
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт									
1.1	а. ДЭХ-ний үйлдвэрлэлт	мян. гкал	38.9	38.1	38.8	0.8	102.0	5	5	5
	б. Цэвэр ус олборлолт	мян.м3	320.0	351.7	306.8	(44.9)	87.2	5	5	4.4
	в. Бохир ус татан зайлуулалт	мян.м3	08.1	262.2	232.2	(30.0)	88.6	5	5	4.4
1.2	Нийт орлого	сая.төг	1,041.5	3,059.9	3,032.1	(27.8)	99.1	5	5	4.6
1.3	Нийт зардал	сая.төг	499.3	3,650.0	3,216.8	(433.2)	88.1	5	5	5
1.4	Цэвэр ашиг алдагдал	сая.төг	(457.8)	(590.1)	(184.7)	405.4	31.3	10	10	9.1
1.5	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал		1.46	1.47	1.35	(0.12)	-8.2	5	5	5
1.6	Нийт авлага	сая.төг	329.5	110.5	433.7	323.2	292.4	5	5	3.3
1.7	Нийт өглөг	сая.төг	1,784.7	1,277.8	1,819.6	541.8	42.4	5	5	2.7
1.8	Хөрөнгө оруулалт, ТЗБАХ, их засварын ажлын биелэлт	сая.төг	128.5	104.7	94.7	(10.0)	9.5	5	5	4.9
1.9	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх							5	5	3
2	Тайлангийн үр дүн							25	25	24.1
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт							6	6	5.7
2.2	Захирлын ажлын тайлан							2	2	2
2.3	Шийдвэрийн хэрэгжилт /ЭХЯ, ТӨБЗГ/							5	5	5
2.4	Худалдан авах ажиллагааны тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад хууль тогтоомжийн биелэлт							5	5	4.5
2.5	Хэрэглэгчийн санал асуулгын дүн							3	3	3
2.6	Ажилтнуудын санал асуулгын дүн							4	4	4
3	Техникийн үзүүлэлт							25	25	25
3.4	Нэмэлт усны зарцуулалт урд оны мөн үеийнхээс /+,-/	мян.м3	19.96	26.15	19.33	(6.8)	34.2	10	10	10
3.6	Үйлдвэрлэлийн осол, аваарь, 1,2 дугаар зэргийн саатал	тоо						15	15	15
	НИЙТ ДҮН							100	100	91.3



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 10


Улаанбаатар хот

**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
Аудитын хорооны 2021 оны ажлын
тайлангийн тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/1021 дүгээр удирдамжийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2021 оны ажлын тайланг “хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос өгсөн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Аудитын хорооны дарга /Ч.Алтантуяа/-д даалгасугай.

ДАРГА



П.ДАВААДОРЖ



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 23 өдөр


Дугаар 11

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 2.11.7 дугаар заалт, Эрчим хүчний сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн а/1021 дүгээр удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг хавсралт ёсоор дэмжсүгэй.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Даваадорж/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Ундраа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА  П.ДАВААДОРЖ